

## **Монголбанк-нд тайлагнах нь**

2022 он 7 сарын 15

### **ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Б. Уламбаярын 2022 оны 2-р улирлын тайлан**

Миний бие Баянсангийн Уламбаяр нь өнгөрсөн 2022 оны 2-р улиралд ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр гэрээний дагуу үргэлжлүүлэн ажиллалаа. 2022 оны 4 сарын 15-нд тайлагнаснаас хойш хугацаанд доорх хурлуудад оролцож ажилласан байна.

Уг тайланг, “Банкны тухай хууль” (“Банкны Хууль” гэх), “Компанийн тухай хууль” (“Компанийн Хууль” гэх), Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Журам” гэх), ХасБанкны дүрэм (“Дүрэм” гэх) гэх мэт холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэсэн ажлаа тусгаж нэгтгэсэн болно.

#### **1. Оролцож ажилласан хурлууд**

##### **2022/04/12 ба 04/25 ТУЗ-ийн ээлжит бус хурал (онлайн)**

- “IPO Prospectus” асуудлыг хэлэлцсэн. Тус асуудлын хүрээнд, (а) “Хуулийн фирмийн дүгнэлт”, (б) үнэлгээний компаний хийсэн “Банкны үнэлгээний тайлан”, (в) “Банкны ХК болох үеийн дүрмийн драфт”, (г) “Ногдол ашгийн бодлого”, (д) “Үнэт цаасны танилцуулга (Prospectus)”, (е) ҮЦК-ийн “Танилцуулга ба хөндлөнгийн дүгнэлт” гэсэн сэдвүүдээр дэлгэрэнгүй ярилцсан.
  - (е) ҮЦК-ийн “Танилцуулга ба хөндлөнгийн дүгнэлт” дээр, миний зүгээс ҮЦК-ийн удирдлагуудад хандаж, банкууд нэг дор IPO хийхэд хөрөнгийн зах зээлд шингээх багтаамж үнэхээр байгаа эсэх, мөн энэ үйл ажиллагаанд цахим сувгуудыг хэрхэн ашиглах боломжтой талаар асууж тодруулсан.
  - (д) “Үнэт цаасны танилцуулга (Prospectus)” сэдвийн хүрээнд, ажилчдын урт хугацааны урамшууллын төлөвлөгөөг хэлэлцэхэд, миний зүгээс, өмнө урамшуулал олгоод тодорхой хүнд “claw back” нөхцөлийг ашигласан, хэрэглэсэн эсэх талаар лавласан.
  - Дээрх (в), (г) болон ажилчдын урт хугацааны урамшууллын төлөвлөгөөг ТУЗ санал нэгтэй баталсан.
  - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

##### **2022/04/27 ТУЗ-ийн ээлжит бус хурал (онлайн)**

- “IPO Prospectus”, “Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлыг зарлах” асуудлуудыг хэлэлцсэн. IPO хийх стратеги, гаргах хувьцааны тоо ширхэг, үнэлгээ, хувьцааны хуваарилалт гэх мэт нарийн параметерүүдийг зөвлөлдсөн.
  - Миний зүгээс, шинээр гаргах болон нийт хувьцааны тоо ширхэгийн хувьд, сүүлийн хэдэн орныг бутархай бишээр, бүхэлчилсэн ширхэгтэйгээр гаргахыг санал болгож, энэ нь дэмжигдсэн.
  - Мөн Банкны үнэлгээ, нэгж хувьцааны үнийн хувьд, өөрийн саналаа хуваалцаж, эцсийн шийдвэр гаргахад идэвхитэй оролцсон.

- Prospectus дээр миний зүгээс, Оюу Толгой төсөл ба түүнтэй холбогдох эрсдэлийг, макро эдийн засгийн эрсдэл дээр тусгайчилж нэмэх шаардлага бий эсэх талаар, анхааруулж тодруулсан.
- 1) Шинээр гаргах хувьцааны тоо, Банкны үнэлгээ, нэгж хувьцааны үнэ, хуваарилалт, Prospectus, Компаний дахин зохион байгуулалтын чиглэлийг ТУЗ санал нэгтэй баталсан.
- 2) Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлыг 5/16-нд зарлан хуралдуулахыг ТУЗ санал нэгтэй баталсан.
- Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

#### **2022/04/26 Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал (онлайн)**

- Тус ээлжит хуралд ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд ажиглагчаар оролцсон.
- *(Компанийн Хуулийн 79.3.3 үүргийн дагуу)*
- Миний бие нийт ТУЗ-ийн хараат бус гишүүдээ төлөөлж, хувь нийлүүлэгчдэд хандсан богино яриа хийсэн.

Банкны үйл ажиллагаа, менежмент болон ТУЗ-ийн засаглал, ашиг сонирхлын зөрчлийн талаар санаа зовохуйц зүйл гараагүйг мэдэгдэхийн зэрэгцээгээр, IPO-г хуульд заасан хугацаанд хэрэгжүүлэхийн тулд холбоотой шийдвэрүүдийг хувь нийлүүлэгчид болон ТУЗ-ийг цаг алдалгүй гаргах талаар ажиллахыг, мөн нэмж ТУЗ-ийн хараат бус 2 гишүүнийг хурдан томилох талаар саналаа илэрхийлсэн болно.

*(Компанийн Хуулийн 79.3.1 үүргийн дагуу)*

#### **2022/05/16 Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурал (онлайн)**

- Тус ээлжит бус хуралд ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд ажиглагчаар оролцсон.
- *(Компанийн Хуулийн 79.3.3 үүргийн дагуу)*
- Уг хурал нь ХасБанкны IPO төлөвлөгөөтэй холбоотой, ТУЗ-ийн 04/27-ны хурлаар шийдсэн асуудлуудыг хувь нийлүүлэгчдээр батлуулах үндсэн зорилготой байсан.

#### **2022/06/20 ТУЗ-ийн ээлжит бус хурал (онлайн)**

- “Компаний дахин зохион байгуулалтын чиглэл”, “Банкны дүрмийн өөрчлөлт”, “Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлыг зарлах” асуудлуудыг хэлэлцсэн.
  - “Компаний дахин зохион байгуулалтын чиглэл”-ийг ТУЗ баталсан.
  - Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлыг 7/18-нд зарлан хуралдуулахыг ТУЗ баталсан.
  - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

#### **2022/06/28 ТУЗ-ийн Аудитын Хорооны ээлжит хурал (онлайн)**

- ТУЗ-ийн улирлын ээлжит хурлын дагуу зохион байгуулагдаж, дараах асуудлуудыг хэлэлцсэн:  
“Үргэлжилсэн дотоод аудит шалгалтын тайлан”, “Орон нутгийн салбаруудын газар дээрх дотоод аудит шалгалтын тайлан”, “IT кибер менежментийн дотоод аудит шалгалтын тайлан”, ”Дотоод аудит шалгалтын follow up”, “Хамаарал бүхий этгээдүүдийн улирлын тайлан”, “2021 оны санхүүгийн аудитын E&Y фирмийн дүгнэлт захиа”.

- “Дотоод аудит шалгалтын follow up”-ийн хувьд, хороогоор хэлэлцэх давтамжыг ярилцаж, Аудитын хорооны гишүүд санал нэгтэй баталсан.
  - Миний зүгээс зөрүүтэй байр суурь байгаагүй.
  - Аудитын Хорооны даргын хувиар, миний бие хурлыг удирдаж явуулсан.
  - Хурлын өмнө, зарим мэдээллийн талаар Дотоод аудитортой ярилцаж тодруулга авсан.

#### **2022/06/28 ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны ээлжит хурал (онлайн)**

- ТУЗ-ийн улирлын ээлжит хурлын дагуу зохион байгуулагдаж, дараах асуудлуудыг хэлэлцсэн:
  - “2022 оны 5-р сарын байдлаарх Эрсдэлийн тайлан”, “Risk Appetite 2022 оны review”, “Зарим муу зээлийн хасалт буюу write-off”, “Оросын Холбооны Улсын эсрэг тавигдсан олон улсын хорионоос үүдэх үр нөлөө”, “2022 оны 5-р сарын байдлаарх хянан нийцүүлэлтийн тайлан”, “Хамаарал бүхий этгээдүүдийн хүсэлт гүйлгээг батлах”.
- “Risk Appetite 2022 оны review”, “Зарим муу зээлийн хасалт буюу write-off”, “Хамаарал бүхий этгээдүүдийн хүсэлт гүйлгээг батлах”-ийг хорооны гишүүд санал нэгтэй баталсан.
  - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

#### **2022/06/28 ТУЗ-ийн Цалин Урамшууллын Хорооны ээлжит хурал (онлайн)**

- Ажиглагчаар оролцсон.
- “Ажилчдын урт хугацааны урамшууллын схем”, “ТУЗ-ийн хараат бус гишүүнийг шалгаруулах процессийн явц”, “Ажилчдын моргэйж болон зээлийн нөхцөлийн жилийн review”, “ТУЗ-ийн өөрийн болон гишүүдийн үнэлгээ (МонголБанк болон хуулийн шаардлагууд)” гэсэн сэдвүүдээр танилцуулга, хэлэлцүүлэг өрнөсөн.

#### **2022/06/29 ТУЗ-ийн ээлжит хурал (онлайн)**

- ТУЗ-ийн Цалин Урамшууллын Хорооны хэлэлцэж баталсан доорх шийдвэрүүдийг ТУЗ-ээр баталсан.
  - 1) “Ажилчдын моргэйж болон зээлийн нөхцөлийн жилийн review”
    - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.
- ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны хэлэлцэж баталсан доорх шийдвэрүүдийг ТУЗ-ээр баталсан.
  - 1) “Risk Appetite 2022 оны review”
  - 2) “Зарим муу зээлийн хасалт буюу write-off”
  - 3) “Хамаарал бүхий этгээдүүдийн хүсэлт гүйлгээг батлах”
    - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.
- ТУЗ-ийн Аудитын Хорооны хэлэлцэж баталсан доорх шийдвэрүүдийг ТУЗ-ээр баталсан.
  - 1) “Дотоод аудит шалгалтын follow up”
    - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.
- Менежментийн зүгээс бэлдсэн дараах асуудлуудтай танилцсан: “Банкны үйл ажиллагааны 2022 оны 5-р сарын байдлаарх явцын тайлан”, “IPO төслийн явц, компаний өөрчлөн зохион байгуулалтын чиглэл”, “AQR Хөрөнгийн чанарын

үнэлгээний явц”, “IT шинэчлэл, дижитал банкны явц”, “D&O даатгал”, “Оросын Холбооны Улсын эсрэг тавигдсан олон улсын хорионоос үүдэх үр нөлөө”.

### **2022/04/21 ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны шийдвэр (онлайн)**

- Доорх хүсэлтийг хороогоор хэлэлцэж дэмжсэн шийдвэр гаргасан.
  - o Менежментийн гишүүний 300 сая төгрөгөөс дээших дүнтэй моргэйжийн зээлийн хүсэлт. Тус хүсэлт нь ашиг сонирхлын зөрчилтэй хүсэлт тул, ТУЗ-ийн хороогоор шийдсэн.  
(Журмын 5.2.3 үүргийн дагуу. Хорооны шийдвэртэй ижил, дэмжсэн санал өгсөн)

### **2022/06 ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны шийдвэр (онлайн)**

- Доорх хүсэлтийг хороогоор хэлэлцэж дэмжсэн шийдвэр гаргасан.
  - o С\*\* компаниас ирсэн зээлийн хүсэлт. Тус компанийн хүсэлт нь Банкны зээлийн хорооны шийдвэрлэх эрхээс хэтэрсэн тул, ТУЗ-ийн хороогоор шийдсэн.  
(Журмын 5.2.3 үүргийн дагуу. Хорооны шийдвэртэй ижил, дэмжсэн санал өгсөн)

### **2. Банкны засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаа**

Банкны засаглал хэвийн сайн хэрэгжиж байна. Хувь нийлүүлэгч, ТУЗ ба удирдлагын багийн хоорондох мэдээлэх процес, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу ажиллаж байна.

ТУЗ ба удирдлагын багийн зүгээс, Банкны ба түүний харилцагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх, аливаа холбогдох хууль журмыг зөрчсөн ноцтой үйлдэл, шийдвэр ажиглагдаагүй.

### **3. Бусад**

- 2022/04/29 ТУЗ-ийн гишүүн Andrzej Witak-тай биечлэн уулзаж, ТУЗ болон ойрын үеийн асуудлуудын талаар санал солилцсон.
- 2022/05/24 IPO-той холбоотой МХБ болон СЗХ-ны шаардлагын дагуу, СЗХ-ны 2020 оны 179-р тогтоолоор баталсан “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын дагуу, ТУЗ-ийн гишүүний хувьд асуулга бөглөж өгсөн.
- 2022/06/24 ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдохоор, Цалин Урамшууллын Хорооноос санал болгогдсон нэр дэвшигчтэй онлайн ярилцлагад оролцсон.
- 2022/06/26 ТУЗ-ийн өөрийн үнэлгээ болон гишүүдийн үнэлгээ (МонголБанк болон хуулийн шаардлагын дагуу)-г бөглөж өгсөн.
- 2022/06/28 ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдохоор, Цалин Урамшууллын Хорооноос санал болгогдсон 2 дохь нэр дэвшигчтэй онлайн ярилцлагад оролцсон.
- 2022/07/05 Банк дээр шинээр санхүүжилт авахтай холбоотойгоор, Европын хөрөнгө оруулалтын сан I\*\*-ийн багийн гишүүдтэй ТУЗ-ийн хараат бус гишүүний хувиар биечлэн уулзаж, мэдээлэл тодруулга өгсөн.

### **4. Компанийн тухай хуулийн 79.3. Хараат бус гишүүний нэмэлт үүргийн хүрээнд**

*79.3.1. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;*

- Уг заалтын дагуу, хяналтыг тавьж зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар анхаарал тавин, бүх хурлуудад оролцож шийдвэрүүдээ гаргасан. Тайлангийн хугацаанд, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого шийдвэрүүд нь уг заалтанд тодорхойлогдохуйц сөргөөр нөлөөлсөн зүйл ажиглагдаагүй болно.
- Энэ талаар, тайлан дахь оролцсон хурал тус бүрийн тайлбарт шаардлагатай бол тэмдэглэж, тайлангийн дээрх 3-р бүлэгт бас тодорхой сийрүүлсэн.

*79.3.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;*

- Уг заалтын хүрээнд, гүйцэтгэх удирдлага нь ил тод, нээлттэй байдлыг үргэлжлүүлэн хэвийн хангаж ажиллаж байгаа бөгөөд, тусгайчлан үүрэг өгч ажиллахаар нөхцөл байдал үүсээгүй болно.

*79.3.3. хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.*

- Тус тайлангийн хугацаанд хувь нийлүүлэгчдийн хуралд 2 удаа оролцож, мөн нийт ТУЗ-ийн хараат бус гишүүдээ төлөөлж хувь нийлүүлэгчдэд хандсан богино мэдээлэл яриа хийсэн болно. Энэ тухай, тайлангийн дээрх 1-р бүлэгт бас тодорхой сийрүүлсэн.

Хүндэтгэсэн,



**Б. Уламбаяр**

**ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн**